

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН  
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААРХ ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРӨХ, БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦ**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар,

Эрх зүйн салбар дахь харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх эрмэлзлийг удирдлага болгон,  
Энэхүү Конвенцийг байгуулахаар шийдвэрлэв.

**I БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1 дүгээр зүйл**

1. Хэлэлцэн тохирогч хоёр улс тус бүр иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх үүрэг хүлээнэ. Энэхүү конвенцийн хүрээнд иргэний хэрэгт иргэний эрх зүй, худалдааны эрх зүй, гэр бүлийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүйн харилцааны эрх, үүргээс үүссэн асуудлууд багтана.
2. Хоёр улсын Хууль зүйн яам энэхүү Конвенцид заасан үүргүүдийн биелэлтийг хангах эрх бүхий төв байгууллага мөн.
3. Эрх бүхий төв байгууллагууд нь үүрэг хүлээсэн улсын хэл дээр шууд харилцах бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанаас үүссэн зардлыг нөхөн төлөхийг шаардахгүй.

### **2 дугаар зүйл**

Эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүссэн Хэлэлцэн тохирогч нэг улсын хүсэлт, үүрэг хүлээсэн нөгөө улсын нийгмийн байгууламж, хууль тогтоомжид харшилж байвал эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

### **3 дугаар зүйл**

Эрх бүхий төв байгууллагууд нь аль нэг улсынхаа хүсэлтээр өөрсдийн улсын хууль тогтоомжийн мэдээлэл болон шүүхийн шийдвэрийн баталгаатай хуулбарыг өгнө.

## **II БҮЛЭГ ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДАХ ЭРХ**

### **4 дүгээр зүйл**

1. Хэлэлцэн тохирогч нэг улсын иргэд нь нөгөө улсын нутаг дэвсгэрт өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулахдаа тухайн улсын иргэдийн нэгэн адилаар шүүхийн байгууллагад чөлөөтэй хандах эрхтэй бөгөөд шүүхийн болоод шүүн таслах ажиллагаанд тэдний адил эрх, үүрэгтэй оролцоно.
2. Өмнөх зүйлүүд нь хоёр улсын аль алины хууль ёсны дагуу байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

### **5 дугаар зүйл**

Хэлэлцэн тохирогч хоёр улсын иргэд аль нэгнийхээ нутаг дэвсгэр дээр гадаадын иргэний хувьд, оршин суух орон байргүй байнга оршин суудаггүйн учир аливаа хэлбэрийг төлбөр, барьцаа төлөх ёсгүй.

### **6 дугаар зүйл**

Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль нэгний шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгч болон гуравдагч этгээд нь аль нэг барьцаа буюу татвараас чөлөөлөгдсөн бол Хэлэлцэн тохирогч энэ улсын эрх бүхий төв байгууллагын хүсэлтээр Хэлэлцэн тохирогч нөгөө улсын төв байгууллагад шүүхийн шийдвэр үнэ төлбөргүй хүргэгдэж гүйцэтгэгдэнэ.

## **III БҮЛЭГ БАРИМТ БИЧГИЙГ ДАМЖУУЛАХ, ГАРДУУЛАХ**

### **7 дугаар зүйл**

Нөгөө улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүмүүст гардуулах шүүхийн болон шүүхийн бус баримт бичгүүдийг Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий төв байгууллагаар дамжуулан хүргүүлнэ.

### **8 дугаар зүйл**

Дамжуулан өгөх баримт бичгүүдийг хоёр хувь үйлдэж, үүрэг хүлээсэн тухайн орны хэл дээр орчуулгыг хавсарган хүргүүлнэ.

### **9 дүгээр зүйл**

1. Баримт бичгүүдийг үүрэг хүлээсэн улс өөрийн хууль тогтоомжид заасан хэлбэрээр гардуулна.

2. Баримт бичгүүдийг гардуулсан болон гардуулах талаар хийх ажлыг хүлээн авсан баримт бичиг, нотлох баримт буюу протоколоор баталгаажуулна. Баримт бичгийн нэг хувийг түүнийг гардуулсан тухай баталгааны хамтаар мөн замаар буцаан хүргүүлнэ.
3. Даалгавар хүлээн авсан улс баримт бичгүүдийг дамжуулах буюу гардуулахад гарсан зардал, төлсөн татварыг нөхөн төлөхийг шаардахгүй.

#### **10 дугаар зүйл**

Хэлэлцэн тохирогч улсын аль нэг нь нөгөөдөө оршин сууж буй өөрийн улсын иргэнд шүүхийн болон шүүхийн бус баримт бичгүүдийг өөрсдийн орны дипломат болон консулын ажилтнуудаар ямар нэг албадлагагүйгээр шууд дамжуулна.

#### **11 дүгээр зүйл**

Өмнөх зүйлүүд нь:

- баримт бичгийг шуудангаар шууд хүрэх газар нь явуулах
- сонирхогч этгээд нь баримт бичгүүдийг хүргүүлэх гэж буй улсын хууль, дүрмийн дагуу төлбөрийг нь төлж баримт бичгийг нотлуулан хүргүүлэх зэрэгт саад учруулахгүй.

### **IV БҮЛЭГ НОТОЛГОО ГАРГУУЛАХ**

#### **12 дугаар зүйл**

1. Нэг улсын шүүхийн байгууллага нь шаардлагатай гэж үзвэл өөрийн явуулж буй нотолгоо бүрдүүлэх үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэхийг нөгөө талдаа шүүхийн даалгаварын хэлбэрээр бичих замаар хүсч болно.
2. Шүүхийн даалгаварт дор дурьдсан зүйлүүдийг тусгасан байна.
  - а/ даалгавар өгч байгаа эрх бүхий байгууллага, хэрэв боломжтой бол даалгаварыг гүйцэтгэх байгууллага
  - б/ зохигчдын нэр хаяг, шаардлагатай бол тэдний төлөөлөгчдийн нэр, хаяг
  - в/ хэргийн байдал, товч утга, нэхэмжлэлийн агуулга
  - г/ нотлох баримтуудДаалгавар эрх бүхий байгууллагын албан ёсны тэмдэг, албан тушаалтны гарын үсэгтэй байна.
3. Уг баримт бичгийг даалгавар хүлээсэн улсын хэл дээр үйлдсэн орчуулгын хамт хүргүүлнэ.

#### **13 дугаар зүйл**

Шүүхийн даалгаварыг эрх бүхий төв байгууллагаар уламжлан дамжуулна. Даалгаварыг гүйцэтгэсэн тухай тухай материалыг түүнийг өгсөн эрх бүхий шүүхийн байгууллагад мөн замаар буцаан хүргүүлнэ.

#### **14 дүгээр зүйл**

1. Шүүхийн даалгаварыг биелүүлэх хэлбэрийг сонгохдоо өөрийн орны хууль тогтоомжийг баримтална.
2. Харин даалгавар хүлээн авсан улсын хууль тогтоомжид харшлах буюу түүний ёс заншилд нийцэхгүй буюу тодорхой бэрхшээлийн улмаас биелүүлэх боломжгүй нөхцөлд даалгавар өгсөн улсын хүссэн тусгай хэлбэрийг хэрэглэнэ.
3. Шүүхийн даалгаварыг аль болох богино хугацаанд гүйцэтгэнэ.

#### **15 дугаар зүйл**

1. Шүүхийн даалгаварыг биелүүлэхтэй холбогдож гарсан аливаа хэлбэрийн татвар, бусад зардлыг нөхөн төлүүлж болохгүй.
2. Даалгавар хүлээн авсан улс нь шинжээчид төлсөн хөлс болон тусгай хэлбэрийг хэрэглэхтэй холбогдож гарсан зардлыг нөхөн төлөхийг даалгавар өгсөн улсаас шаардах эрхтэй.

#### **16 дугаар зүйл**

Хэлэлцэн тохирогч улсууд нь өөрсдийн иргэнд хамаарсан шүүхийн даалгаварыг дипломат болон консулын газруудаараа ямар нэг албадлагагүйгээр дамжуулан гүйцэтгүүлэх эрхтэй.

### **V БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, БИЕЛҮҮЛЭХ**

#### **17 дугаар зүйл**

Энэхүү бүлгийн заалтыг иргэний хэргийн талаар гарсан хоёр улсын шүүхийн шийдвэр, түүнчлэн гэм хорыг нөхөн төлүүлэх талаар гарсан эрүүгийн хэргийн таслан шийдвэрлэх тогтоолд хамааруулан хэрэглэнэ.

## **18 дугаар зүйл**

Хоёр улсын аль нэгнийх нь шүүхийн гаргасан шийдвэр дараах нөхцөлийг хангасан тохиолдолд нөгөө улсын нутаг дэвсгэр дээр хүлээн зөвшөөрөгдөж гүйцэтгэж болно. Үүнд:

1. Шүүхийн даалгавар хүлээн авсан улсын хуулийн дагуу эрх бүхий шүүх гаргасан байна;
2. Маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ даалгавар хүлээн авсан улсын нутаг дэвсгэр дээрх эрх зүйн зөрчилтэй хэм хэмжээг зохицуулахад хэрэглэдэг хуулийг баримтална. Хэрэв даалгавар хүлээн авагч улсын эрх зүйн зөрчилтэй хэм хэмжээг зохицуулан хэрэглэдэг хуулийг хэрэглэсэн ч адил үр дүнтэй байвал аль ч улсын хуулийг хэрэглэж болно;
3. Хуулийн дагуу гарч хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр заавал биелэгдэх ёстой. Харин хүүхдийн тэтгэвэр гаргуулах, насанд хүрээгүй хүүхдийг асран хамгаалах, хүүхэдтэй уулзаж байх эрхийн тухай шүүхийн шийдвэрийг түүнийг гаргасан улсын нутаг дэвсгэр дээр шууд биелүүлж болно;
4. Зохигчид шүүхийн зарлан дуудах бичгийг байнга авч байсан буюу өөрсдийгөө төлөөлсөн байх ёстой. Хэрэв өөрсдөө байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй бол зохигчид зарлан дуудах бичгийг цаг тухайд нь авч, өөрсдийгөө хамгаалах талаар бололцоотой хугацаагаар хангагдаж байсан байх ёстой;
5. Шийдвэр нь даалгавар хүлээн авсан улсын нийгмийн хэв журамд харшлах зүйл агуулаагүй байна;
6. Анх хэрэг гарсан орны хувьд ижил зохигчид оролцсон хэргийн ижил бүрэлдэхүүн, нөхцөлтэй маргаан нь:
  - Анх даалгавар авсан улсын шүүхээр хэлэлцүүлэгдээд байгаа бол;
  - Даалгавар мэдэгдэхээс өмнө даалгавар хүлээн авагч улсад уг маргаанаар шийдвэр гараагүй бол;
  - Даалгавар хүлээн авагч улсад шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөд шаардагдах нөхцлийг хангасан хэдий ч даалгавар хүлээн авагчид өгөхөөс өмнө гуравдагч улсад уг маргаанаар шийдвэр гараагүй бол.

## **19 дүгээр зүйл**

1. Даалгавар хүлээн авсан улсын шүүх нөгөө улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг баримтална.
2. Даалгавар хүлээн авсан улсын шүүхийн байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө улсын шүүхийн шийдвэрийг хянаж үзэхгүй.
3. Хэрэв шүүхийн шийдвэр нь хэд хэдэн хэсгээс бүтсэн байвал тэдгээрийг хэсэгчлэн гүйцэтгэж болно.

## **20 дугаар зүйл**

Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, түүнийг биелүүлэхийг шаардаж буй этгээд дараах баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Шийдвэрийн эх, хуулбар хувь, түүний үнэнийг батлах бүхий л баримт бичгүүд;
2. Шийдвэрт зохих гарын үсэг зурж, шийдвэрийг албан ёсоор танилцуулсан буюу мэдэгдсэнийг нотлох аливаа баримт бичиг;
3. Шүүхэд дуудагдсан зохигчид ирээгүй бол түүнд илгээсэн зарлан дуудах хуудасны баталгаатай хувь, түүнчлэн тэрхүү зарлан дуудах хуудас нь зохигчид цаг тухайдаа очсон гэдгийг нотлох аливаа баримт бичиг;
4. Шийдвэр нь түүнийг гаргасан улсын нутаг дэвсгэр дээр заавал биелэгдэх бөгөөд нялх хүүхдийг тэжээх, бага насны хүүхдийг асрах, уулзахтай холбогдуулан шийдвэр гаргаснаас бусад нөхцөлд энгийн журмаар давж заалдах эрхгүй болсон гэдгийг нотлох баримт.

Энэхүү баримт бичгийг диипломат болон консулын ажилтнууд эсвэл нөгөө улсын нутаг дэвсгэр дээр ийм эрх эдэлж буй этгээдээр нотлуулсан орчуулгын хамт гардуулна.

## **VI БҮЛЭГ ИРГЭНИЙ БАЙДАЛ БА ХУУЛИЙН ЗААЛТААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

### **21 дүгээр зүйл**

1. Тухайн улс нөгөө улсын албан хэрэгцээнд зориулан, тусгайлан хүссэний дагуу түүний иргэдийн иргэний байдлын тухай баримт бичиг, шүүхийн шийдвэрийг мэдээнэ.
2. Иргэний гэр бүлийн байдлын талаарх хүсэлт, баримт бичгийг дипломат буюу консулын шугамаар, шүүхийн шийдвэрийн талаарх хүсэлт, баримтуудыг эрх бүхий төв байгууллагуудаар тус тус дамжуулна.

## **22 дугаар зүйл**

Энэ Конвенцид дурдагдсан баримт бичгүүд нь хууль ёсны эсэхийг нотлох шаардлагагүй.

## **VII БҮЛЭГ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

## **23 дугаар зүйл**

Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох бэрхшээлийг дипломат шугамаар зохицуулна.

## **24 дүгээр зүйл**

Хэлэлцэн тохирогч хоёр улс нь энэхүү Конвенцийг батлахдаа өөрсдийн Үндсэн хуульд заасан журмыг баримтлах бөгөөд уг журмыг гүйцэтгэсний дараа нөгөө улсдаа албан ёсоор мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль нэг нь мэдэгдлийг хамгийн сүүлд хүлээн авснаас хойш хоёр дахь сарын эхний өдрөөс энэхүү Конвенц нь хүчин төгөлдөр болно.

## **25 дугаар зүйл**

Энэ Конвенцийг тодорхой бус хугацаагаар байгуулах ба аль нэг улс нь түүнийг хэзээ ч цуцалж болох бөгөөд энэ тухайгаа бичгээр мэдэгдсэнийг нөгөө улс хүлээн авсан өдрөөс хойш 6 сар өнгөрмөгц энэхүү Конвенцийг цуцалсанд тооцно.

Энэхүү Конвенцийг Парис хотноо монгол, франц хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх адил хүчинтэй байна.

- 000-